

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/38/НА-СТА-ТЗШ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2022 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. Аудитын илрүүлэлт	15
5.2 Төлбөрийн акт	15
5.3 Албан шаардлага	15
5.4 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

2023.08.24 № 01/178
танай _____-ны № _____-т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.МӨНГӨН-
ЭРДЭНЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын төсвөөс 3,093.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авч үр ашиггүй зардал гаргасан, аймгийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын автомашин хэрэглэж 2,079.2 мянган төгрөгийн шатахууны зардал гаргасан зэрэг зөрчил илэрсэн.

Аудитын гол асуудал

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 160,022.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хуулийн хугацаанд гаргаж тайлагнаагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	166,271,413.66	511,903,169.39
33	АВЛАГА	6,053,500.00	49,877,974.73
335	Бусад авлага	6,053,500.00	49,877,974.73
3351	Байгууллагаас авах авлага	00.00	9,023,900.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	6,053,500.00	40,854,074.73
35	БАРАА МАТЕРИАЛ	160,217,913.66	462,025,194.66
354	Хангамжийн материал	130,337,913.66	430,605,194.66
35420	Аж ахуйн материал	94,904,113.66	374,865,894.66
35440	Түлш, шатах тослох материал	00.00	2,440,000.00
35450	Барилгын засварын материал	1,902,600.00	1,312,100.00
35460	Хүнсний материал	00.00	2,516,000.00
35470	Бусад хангамжийн материал	33,531,200.00	49,471,200.00
35600	Мал амьтад	29,880,000.00	31,420,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,750,818,216.40	3,637,964,493.03
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,750,818,216.40	3,637,964,493.03
392	Биет хөрөнгө	3,313,156,276.16	3,202,954,712.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,840,961,787.40	2,840,961,787.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	-123,296,252.04	-239,402,352.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	372,280,000.00	372,280,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-160,191,333.17	-208,670,666.41
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	299,020,280.00	455,522,780.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-115,433,930.00	-185,696,498.89
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	182,656,153.00	186,176,153.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-60,735,604.29	-81,925,322.97
39214	Бусад үндсэн хөрөнгө	96,748,895.00	96,748,895.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-18,853,719.74	-33,040,062.14
393	Биет бус хөрөнгө	437,661,940.24	435,009,780.28
39301	Програм хангамж	22,482,000.00	22,482,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-22,482,000.00	-22,482,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	453,574,900.00	453,574,900.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-15,912,959.76	-18,565,119.72
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,917,089,630.06	4,149,867,662.42
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,717,894.32
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,717,894.32
413	Өглөг	00.00	1,717,894.32
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	185,000.00
4136	Бусад өглөг	00.00	1,532,894.32
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	1,532,894.32
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,917,089,630.06	4,148,149,768.10
51	Засгийн газрын хувь оролцоо	3,917,089,630.06	4,148,149,768.10
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,352,461,521.65	1,352,461,521.65
51101	Өмч: - төрийн	1,352,461,521.65	1,352,461,521.65
512	Хуримтлагдсан үр дүн	-22,198,460.12	208,861,677.92
51210	Өмнөх үеийн үр дүн	-22,198,460.12	-22,198,460.12
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	231,060,138.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,586,826,568.53	2,586,826,568.53
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,917,089,630.06	4,149,867,662.42

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,549,444,982.40	4,581,041,433.00

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	940,413,727.40	674,110,243.00
120	Нийтлэг татварын бус орлого	940,413,727.40	674,110,243.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	933,648,727.40	659,499,243.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,583,479.00	18,364,602.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	760,000.00	1,737,100.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	910,305,248.40	639,397,541.00
120009	Бусад орлого	6,765,000.00	14,611,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,609,031,255.00	3,906,931,190.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	475,354,955.00	231,751,090.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	36,640,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	475,354,955.00	155,091,090.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	40,020,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,133,676,300.00	3,675,180,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,133,676,300.00	3,675,180,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,920,676,578.75	4,152,868,694.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,920,676,578.75	4,152,868,694.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,691,964,668.23	3,784,560,917.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,054,293,424.56	999,197,810.08
210101	Үндсэн цалин	665,086,724.56	681,498,188.34
210102	Нэмэгдэл	249,777,800.00	183,439,166.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	97,944,000.00	76,445,297.00
210104	Урамшуулал	00.00	33,679,573.00
210105	Гэрээт ажлын хөлс	41,484,900.00	24,135,585.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,895,440.00	122,509,324.47
210201	Тэтгэврийн даатгал	90,241,240.00	84,246,740.13
210202	Тэтгэмжийн даатгал	9,913,600.00	9,363,025.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,930,800.00	7,318,940.78
210204	Ажилгүйдлийн даатгал	1,982,700.00	1,822,376.90
210205	Эрүүл мэндийн даатгал	19,827,100.00	19,758,241.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	225,910,919.91	238,821,248.83
210301	Гэрэл, цахилгаан	6,892,463.91	7,871,970.63
210302	Түлш, халаалт	212,419,700.00	224,256,990.20
210303	Цэвэр, бохир ус	6,598,756.00	6,692,288.00
2104	Хангамж, бараа материалын зардал	122,911,091.17	155,713,828.81
210401	Бичиг хэрэг	21,630,049.00	24,305,750.00
210402	Тээвэр, шатахуун	60,857,166.50	99,821,200.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,200,070.01	10,278,040.51
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	533,300.00	463,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,537,884.00	17,930,638.00
210408	Бараа материал акталсны зардал	22,152,621.66	2,915,000.00
2105	Нормативт зардал	1,000,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	75,857,100.00	80,649,700.00
210602	Тавилга	750,000.00	00.00
210604	Урсгал засвар	75,107,100.00	80,649,700.00
2107	Томилолт, зочны зардал	14,325,600.00	67,378,900.00
210702	Дотоод албан томилолт	14,325,600.00	67,378,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,028,405.00	63,862,957.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,187,480.00	54,166,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,615,025.00	2,500,000.00

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	192,000.00	292,532.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,171,000.00	6,064,000.00
210807	Газрын төлбөр	785,900.00	740,925.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,029,742,687.59	2,056,427,148.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,840,463,564.40	1,779,146,325.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,057,100.00	4,404,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	158,222,023.19	272,876,223.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	228,711,910.52	368,307,777.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	85,315,798.00	85,361,047.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	12,709,109.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,000,000.00	15,755,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	45,138,000.00	34,502,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,177,798.00	22,393,838.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	143,396,112.52	282,946,730.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	143,396,112.52	282,946,730.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	628,768,403.65	428,172,738.04
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	3,285,400.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	00.00	3,285,400.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,942,860.03	200,398,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,942,860.03	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	200,398,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,942,860.03	-197,112,600.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	625,825,543.62	231,060,138.04

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн / төгрөгөөр /
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,352,461,521.65	2,592,385,961.43	-648,024,003.74	3,296,823,479.34
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	625,825,543.62	625,825,543.62
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,352,461,521.65	2,586,826,568.53	-22,198,460.12	3,917,089,630.06
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,352,461,521.65	2,586,826,568.53	-22,198,460.12	3,917,089,630.06
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	231,060,138.04	231,060,138.04
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,352,461,521.65	2,586,826,568.53	208,861,677.92	4,148,149,768.10

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,632,974,734.00	3,927,100,087.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,343,479.00	20,101,702.00
120	Нийтлэг татварын бус орлого	23,343,479.00	20,101,702.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,343,479.00	20,101,702.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,583,479.00	18,364,602.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	760,000.00	1,737,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,609,631,255.00	3,906,998,385.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	475,954,955.00	231,751,090.00

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	36,640,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	475,354,955.00	155,091,090.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	600,000.00	40,020,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,133,676,300.00	3,675,180,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,133,676,300.00	3,675,180,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	67,195.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	67,195.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,601,157,284.00	3,927,100,087.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,601,157,284.00	3,927,100,087.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,369,888,071.48	3,549,852,852.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,054,293,424.56	1,036,998,384.81
210101	Үндсэн цалин	665,086,724.56	719,298,763.07
210102	Нэмэгдэл	249,777,800.00	183,439,166.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	97,944,000.00	76,445,297.00
210104	Урамшуулал	00.00	33,679,573.00
210105	Гэрээт ажлын хөлс	41,484,900.00	24,135,585.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,895,440.00	122,469,724.47
210201	Тэтгэврийн даатгал	90,241,240.00	84,207,140.13
210202	Тэтгэмжийн даатгал	9,913,600.00	9,363,025.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,930,800.00	7,318,940.78
210204	Ажилгүйдлийн даатгал	1,982,700.00	1,822,376.90
210205	Эрүүл мэндийн даатгал	19,827,100.00	19,758,241.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	225,910,919.91	237,288,354.51
210301	Гэрэл, цахилгаан	6,892,463.91	6,339,076.31
210302	Түлш, халаалт	212,419,700.00	224,256,990.20
210303	Цэвэр, бохир ус	6,598,756.00	6,692,288.00
2104	Хангамж, бараа материалын зардал	94,285,099.01	118,210,756.81
210401	Бичиг хэрэг	19,005,449.00	18,916,400.00
210402	Тээвэр, шатахуун	46,726,700.00	72,604,771.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,480,150.01	10,035,731.51
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	533,300.00	463,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,539,500.00	16,190,654.00
2105	Нормативт зардал	1,000,000.00	1,999,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,999,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	82,597,400.00	82,525,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,751,000.00	00.00
210602	Тавилга	750,000.00	00.00
210604	Урсгал засвар	76,096,400.00	82,525,100.00
2107	Томилолт, зочны зардал	14,325,600.00	42,810,200.00
210702	Дотоод албан томилолт	14,325,600.00	42,810,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,500,025.00	366,491,422.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,370,100.00	351,614,965.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,615,025.00	2,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	192,000.00	292,532.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,460,000.00	11,244,000.00
210807	Газрын төлбөр	785,900.00	740,925.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,723,080,163.00	1,541,059,910.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,688,227,974.00	1,501,405,710.00

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	34,852,189.00	39,654,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	231,269,212.52	377,247,234.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	87,873,100.00	90,172,004.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	67,195.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	17,234,109.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,000,000.00	15,755,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	45,138,000.00	34,202,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,735,100.00	22,912,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	143,396,112.52	287,075,230.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	143,396,112.52	287,075,230.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	31,817,450.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	31,817,450.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31,817,450.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	31,817,450.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	31,817,450.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-31,817,450.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /					
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН				
2	УРСГАЛ ЗАРДАЛ	3,694,680,100.0	3,412,335,071.6	282,345,028.4	92.4
21	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,694,680,100.0	3,412,335,071.6	282,345,028.4	92.4
210	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,601,959,400.0	3,322,230,262.6	279,729,137.4	92.2
2101	Үндсэн цалин	1,062,979,400.0	1,012,862,799.8	50,116,600.2	95.3
210101	Үндсэн цалин	712,779,000.0	719,298,763.1	-6,519,763.1	100.9
210102	Нэмэгдэл	252,256,400.0	183,439,166.7	68,817,233.3	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	97,944,000.0	76,445,297.0	21,498,703.0	78.1
210104	Урамшуулал	00.0	33,679,573.0	-33,679,573.0	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	125,479,400.0	119,095,808.5	6,383,591.5	94.9
210201	Тэтгэврийн даатгал	86,951,900.0	80,833,224.1	6,118,675.9	93.0
210202	Тэтгэмжийн даатгал	9,631,900.0	9,363,025.6	268,874.4	97.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,705,500.0	7,318,940.8	386,559.2	95.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,926,400.0	1,822,376.9	104,023.1	94.6
210205	Эрүүл мэндийн даатгал	19,263,700.0	19,758,241.1	-494,541.1	102.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	253,100,500.0	237,288,354.5	15,812,145.5	93.8
210301	Гэрэл, цахилгаан	7,500,000.0	6,339,076.3	1,160,923.7	84.5
210302	Түлш, халаалт	238,400,500.0	224,256,990.2	14,143,509.8	94.1

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	7,200,000.0	6,692,288.0	507,712.0	92.9
2104	Хангамж, бараа материалын зардал				
		118,089,500.0	115,410,756.8	2,678,743.2	97.7
210401	Бичиг хэрэг	18,000,000.0	18,916,400.0	-916,400.0	105.1
210402	Тээвэр, шатахуун	70,000,000.0	69,804,771.3	195,228.7	99.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,500,000.0	10,035,731.5	3,464,268.5	74.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	533,300.0	463,200.0	70,100.0	-13.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,056,200.0	16,190,654.0	-134,454.0	100.8
2105	Нормативт зардал				
		2,000,000.0	1,999,000.0	1,000.0	00.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.0	1,999,000.0	1,000.0	00.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал				
		82,700,000.0	82,525,100.0	174,900.0	99.8
210604	Урсгал засвар	82,700,000.0	82,525,100.0	174,900.0	99.8
2107	Томилолт, зочны зардал				
		44,865,900.0	42,810,200.0	2,055,700.0	95.4
210702	Дотоод албан томилолт	44,865,900.0	42,810,200.0	2,055,700.0	95.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж				
		394,575,600.0	366,491,422.0	28,084,178.0	92.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	379,462,400.0	351,614,965.0	27,847,435.0	92.7
210803	Даатгалын үйлчилгээ	2,500,000.0	2,500,000.0	00.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	467,200.0	292,532.0	174,668.0	62.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.0	99,000.0	11,000.0	90.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,250,000.0	11,244,000.0	6,000.0	99.9
210807	Газрын төлбөр	786,000.0	740,925.0	45,075.0	-05.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал				
		1,518,169,100.0	1,343,746,821.0	174,422,279.0	88.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,478,514,900.0	1,304,092,621.0	174,422,279.0	88.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	39,654,200.0	39,654,200.0	00.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ				
		92,720,700.0	90,104,809.0	2,615,891.0	97.2
2132	Бусад урсгал шилжүүлэг				
		92,720,700.0	90,104,809.0	2,615,891.0	97.2
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	20,000,000.0	17,234,109.0	2,765,891.0	-13.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,755,800.0	15,755,800.0	00.0	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	34,202,300.0	34,202,300.0	00.0	00.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,762,600.0	22,912,600.0	-150,000.0	100.7
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР				
		3,694,680,100.0	3,412,335,071.6	282,345,028.4	92.4
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
		3,675,180,100.0	3,393,970,469.6	281,209,630.4	92.3
132001	Орон нутгийн төсвөөс	3,675,180,100.0	3,393,970,469.6	281,209,630.4	92.3
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС				
		19,500,000.0	18,364,602.0	1,135,398.0	-05.8
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,500,000.0	18,364,602.0	1,135,398.0	-05.8
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО				
		77.00	77.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	11.00	11.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	34.00	34.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	32.00	32.00	00.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Гүйцэтгэл	

I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	227,622,590.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	227,622,590.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	227,622,590.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,135,585.00
210105	Гэрээт ажлын хөлс	24,135,585.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,373,916.00
210201	Тэтгэврийн даатгал	3,373,916.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,800,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	197,313,089.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	197,313,089.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	227,622,590.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	227,622,590.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	32,511,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	155,091,090.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	40,020,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I)	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

3. Аудитын тайлан

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь Монгол улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх болон аймгийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд чиглэгдсэн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгэм төрийн захиргааны байгууллагын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр төсөл боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, холбогдох арга хэмжээг зохицуулах үйл ажиллагааг эрхэлнэ. Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албад нь Тамгын газраас боловсруулж, Засаг даргын шийдвэрлэсэн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүргийг хүлээн ажилладаг орон нутгийн төсвийн байгууллага юм.

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2022 оныг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил болгон зарласан байна.

3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчны талаар: Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомж журам зааврын мөрдөн ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй бага байна гэж үзлээ.

Тайлант онд Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/137 тушаалаар байгууллагын дотоод хяналтын нэгжийг 7 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан байна. Тус зөвлөл нь 2021 онд нийт 13 асуудалд дотоод хяналт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Дотоод хяналтын зөвлөлийн ажлын гүйцэтгэлийг хянаж үзэхэд 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан 6 асуудалд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

Санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсрол соёлын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Санхүү төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 232,778.0 мянган төгрөгөөр буюу 6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	6,053.5	49,878.0	43,824.5
Бараа материал	160,217.9	462,025.2	301,807.3
Биет хөрөнгө	3,313,156.3	3,202,954.7	-110,201.6
Биет бус хөрөнгө	437,661.9	435,009.8	-2,652.2
Нийт хөрөнгө	3,917,089.6	4,149,867.7	232,778.0
Хуримтлагдсан үр дүн	-22,198.5	208,861.7	231,060.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,917,089.6	4,149,867.7	232,778.0

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна. Тайланд онд авлага, үндсэн хөрөнгө, бараа материал дансанд дараах хөдөлгөөн хийгдсэн байна. Үүнд:

- Захиргааны ерөнхий хуулийн 103.1 дэх заалтын дагуу 2 ажилтанд ажилгүй байсан хугацааны цалин хөлс 37,366.2 мянган төгрөгийг олгож, буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлэхээр авлага үүсгэсэн байна.
- Бараа материал данс 462,025.2 мянган төгрөг болж 301,807.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж ашиглагч байгууллагууд руу шилжээгүй хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн нь гол нөлөөг үзүүлж байна.

- Орон нутгийн хөгжлийн сан болон улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 160,022.5 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.
- Гэрэл цахилгааны өглөг 1,532.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хуримтлагдсан үр дүн 231,060.1 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд 2,620,524.9 мянган төгрөгийн зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төсөвлөж дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 701,463.2 мянган төгрөгөөр бууруулж, 1,919,061.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 1,775,618.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 3,694,680.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,412,335.0 мянган төгрөг буюу 92.4 хувьтай байгаа ба 282,345.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Хүснэгт 1. Хөтөлбөр, арга хэмжээний зардал

/мянган төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	3,694,680.1	3,412,335.0	282,345.1	92.4
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,692,903.7	1,611,296.6	81,607.1	95.2
80307	Шүүхийн шийдвэрийн дагуу олгох төлбөр	23,000.0	2,700.0	20,300.0	11.7
80112	Нийтлэг үйлчилгээ	68,540.8	64,015.2	4,525.6	93.4
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	221,500.0	213,401.8	8,098.2	96.3
80305	Биеийн тамирын уралдаан, тэмцээн	70,430.0	65,197.2	5,232.8	92.6
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	76,964.9	74,349.0	2,615.9	96.6
80815	Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох нөхөн олговор	15,755.8	15,755.8	0.0	100.0
80309	Уналга, цугларалт, бэлтгэл сургууль	57,751.5	57,751.5	0.0	100.0
82324	Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа	3,800.0	3,800.0	0.0	100.0
82617	Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сургалт, сурталчилгаа	138,500.0	129,424.0	9,076.0	93.4
82801	Улсын их баяр наадам	280,833.4	274,587.8	6,245.6	97.8
82808	Бусад баяр ёслол, тэмдэглэлт арга хэмжээ	63,000.0	62,861.5	138.5	99.8
81507	Мал тооллого	5,000.0	5,000.0	0.0	100.0
81103	Эрсдлийн сангийн нөөц хөрөнгө	2,000.0	2,000.0	0.0	0.0
81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	974,700.0	832,194.6	142,505.4	85.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дараах орлогууд орсон байна. Үүнд:

- Архивын ерөнхий газраас архивын тасгийн гэрээт ажиллагсдын цалинд 27,509.5 мянган төгрөг
- Мөсний баярын орлого 40,020.0 мянган төгрөг
- Төрийн албаны зөвлөлөөс төрийн албаны шалгалт зохион байгуулах зардалд 6,148.0 мянган төгрөг
- Мөсний баярын үйл ажиллагаанд Байгаль орчин аялал жуулчлалын яам болон Оюу хийц ХХК-аас 26,640.0 мянган төгрөг
- Аймгийн Засаг дарга данснаас мөсний баяр болон аймгийн аварга малчдын шагналд зориулж 76,000.0 мянган төгрөг
- НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрөөс сургалтын зардалд 48,751.6 мянган төгрөгийн орлогыг тус тус хүлээн авсан байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас зохих журмын дагуу эрхийг нээлгэж, зарцуулалтыг хийсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны 2/149 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,920,676.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 78,413.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 буюу 62,730.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг сорилыг хэрэгжүүллээ. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор дараах зөрчлүүд илэрсэн болно. Үүнд:

1. Төсвийн хөрөнгөөр 3,903.8 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл бэлтгэсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авахыг хориглоно гэсэн заалттай нийцэхгүй байна.
2. Улаанбаатар хот болон бусад газарт ажиллахдаа Албан ажлын томилолт, удирдамж, ажлын тайлангүйгээр 1,405.8 мянган төгрөгийн шатахууны зардал гаргасан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.3.Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно гэсэн заалттай нийцэхгүй байна.
3. Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй автомашиныг аймгийн Засаг даргаас бусад албан тушаалтан дотор үйлчилгээнд ашиглаж 673.4 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.2.Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.

Дээрх зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ. Мөн дараах зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

1. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон бусад арга хэмжээний хоолны зардалд 49,181.3 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5 батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3.сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх; гэсэн заалттай нийцэхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2022 онд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 149 мэдээллийг хугацаанд мэдээлж 2 мэдээллийг оруулах хугацаа болоогүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хуулийн хугацаанд гаргаж тайлагнаагүй нь Засгийн газрын 2020 оны 2017 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын 3.3 "Зохион байгуулалтын нэгж 6, 12 дугаар

сард төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шууд захирагчид тайлагнана", 4.5.1. сум, дүүрэг, аймаг, нийслэл дэх агентлаг, орон нутгийн өмчит хуулийн этгээд, орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрын төсвийн шууд захирагч 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны II улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийж алдаа зөрчлийг арилгах 8 зөвлөмжийг хүргүүлсэн. Зөвлөмжийг хэрэгжилтийг хянаж үзэхэд 50 хувийн гүйцэтгэлтэй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар байгууллагын тооцооны үлдэгдлийг баталгаажуулах, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар 3 зөвлөмжийг өгч, тайлант онд 89.7 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	760.7	1	435.5	57.2
Албан шаардлага	1	205,700.0	1	205,700.0	100
Зөвлөмж	5	271,200.0	5	271,200.0	100
Нийт дүн	7	532,100.0	7	477,335.5	89.7

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцгойлон үзэх асуудал байхгүй байна.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар 27,550.0 мянган төгрөгийн алдааг илрүүлж аудитын хугацаанд бүрэн залруулсан. Үүнд:

1. Бараа материалын үлдэгдлийг 27,550.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байсныг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нийт 63,978.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 5,983.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 49,181.3 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 8,814.0 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өглөө.

5.2 Төлбөрийн акт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүдэд нийт 5,983.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Улаанбаатар хот болон бусад газарт ажиллахдаа Албан ажлын томилолт, удирдамж, ажлын тайлангүйгээр 1,405.8 мянган төгрөгийн шатахууны зардал гаргасан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.3.Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно гэсэн заалттай нийцэхгүй байна.
2. Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй автомашиныг аймгийн Засаг даргаас бусад албан тушаалтан дотор үйлчилгээнд ашиглаж 673.4 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.2.Аймаг, нийслэл, дүүргийн

иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно гэсэн заалттай нийцэхгүй байна.

3. Төсвийн хөрөнгөөр 3,903.8 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл бэлтгэсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авахыг хориглоно; Төсвийн тухай хуулийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5 батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

5.3 Албан шаардлага

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон бусад арга хэмжээний хоолны зардалд 49,181.3 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5 батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3.сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх; гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн албан шаардлага:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулах

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой

1.1. Илрүүлэлт:

Суурин утасны төлбөр 249.6 мянган төгрөгийг тээвэр шатахууны зардлаас шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт болон Сангийн сайдын 190 дүгээр тушаалаар батлагдсан Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавартай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

2. Төсвийн зарцуулалттай холбоотой

2.1. Илрүүлэлт:

Аймгийн Засаг даргын захирамжаар 85-аас 90 насны 312 ахмадуудад 8,564.4 мянган төгрөгийн Аймгийн Засаг даргын гарын бэлгийг хүргүүлсэн нь Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийн заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Ахмад настнуудад гарын бэлэг хүргүүлэхдээ Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах

3. Хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалттай холбоотой

3.1. Илрүүлэлт:

Байгууллагын данс бүртгэлд байгаа үндсэн хөрөнгийг кодлуулан бүртгээгүй байна. Энэ нь хөрөнгө солигдох дутагдах эрсдэл үүсэж байна. Байгууллагын авто тээврийн хэрэгсэл, барилга байгууламжид хувийн хэрэг хөтлөхгүй байгаагаас шалтгаалан автомашины урсгал засвар, ашиглалтын нормыг тооцох боломжгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын эзэмшилд байгаа үндсэн хөрөнгөд хувийн хэрэг хөтөлж, ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах

4. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй холбоотой

4.1. Илрүүлэлт:

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хуулийн хугацаанд гаргаж тайлагнаагүй нь Засгийн газрын 2020 оны 2017 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын 3.3 "Зохион байгуулалтын нэгж 6, 12 дугаар сард төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шууд захирагчид тайлагнана", 4.5.1. сум, дүүрэг, аймаг, нийслэл дэх агентлаг, орон нутгийн өмчит хуулийн этгээд, орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрын төсвийн шууд захирагч 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийн шууд захирагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хуулийн хугацаанд гаргаж тайлагнаж хэвших

5. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой

5.1. Илрүүлэлт:

Дотоод хяналтын зөвлөл нь 2022 онд нийт 13 асуудалд дотоод хяналт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Дотоод хяналтын ажлын гүйцэтгэлийг хянаж үзэхэд 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан 6 асуудалд хяналт хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан " Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.7.1-дэх заалттай нийцэхгүй байгаа ба үнэн ба зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2. Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналтын зөвлөлийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан асуудлын дагуу хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлж, байгууллагыг эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан.	1	27,550.0			1	27,550.0	1	27,550.0				
Дүн	1	27,550.0			1	27,550.0	1	27,550.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах	Хууль, хяналтын

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

									албан шаардлага		байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой	2	55,164.3	1	5,983.0	1	49,181.3						
Төсвийн зарцуулалттай холбоотой	1	8,564.4					1	8,564.4				
Төсвийн зарцуулалттай холбоотой	1	249.6					1	249.6				
Хөрөнгийн ашиглалт хадгалалттай холбоотой	1	0					1	0				
Дүн	5	63,978.3	1	5,983.0	1	49,181.3	3	8,814.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/						
			Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй холбоотой	1	0						1	0
Дотоод хяналт хариуцлагатай холбоотой	1	0						1	0
Дүн	2	0						2	0

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АХЛАХ АУДИТОР

Б.ДАВААНЫМ ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

2/24



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2023 оны 02 сарын 24 өдөр

№ 22/А22-701/18/ХАА-2023/38
ХАА-ЦТА-ТШБ

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Байгууллагын төсвөөс 3,903,800.0 (гурван сая есөн зуун гурван мянга найман зуу) төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авч үр ашиггүй зардал гаргасан.
2. Аймгийн Засаг даргаас бусад албан тушаалтан дотор үйлчилгээнд албан тушаалын автомашин хэрэглэж 673,400.0 (зургаан зуун далан гурван мянга дөрвөн зуу) төгрөг, Улаанбаатар хот болон бусад газарт ажиллахдаа Албан ажлын томилолт, удирдамж, ажлын тайлангүйгээр 1,405,800.0 (нэг сая дөрвөн зуун таван мянга найман зуу) төгрөг, нийт 2,079,200.0 (хоёр сая далан есөн мянга хоёр зуу) төгрөгийн шатахууны зардал гаргасан байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар үйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5."төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"-гүй байх, 6.2.Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно", гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаа бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтуудыг үндэслэн

ТОГТООХ нь:

1. Байгууллагын төсвөөс үр ашиггүй зардал гаргаж бэлэг дурсгалын зүйл худалдан авсан болон шатахууны зардалд зарцуулсан нийт 5,983,000 (таван сая есөн зуун наян гурван мянга) төгрөгийг Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнгөн-Эрдэнэ, нягтлан бодогч Д.Балжинням нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР:



А.ЭРДЭНЭБААТАР

Г.ИЧИНХОРЛОО

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 24 өдөр

№ 21/АЭЭ-70648/МАН-2023/38
МАН-СТА - ТМЗ

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон бусад арга хэмжээний хоолны зардалд 49,181,300.0 (дөчин есөн сая нэг зуун наян нэгэн мянга гурван зуу) төгрөгийг зарцуулсан байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5 батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3.сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх; гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журмын 4.2.1.11-т "Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно" гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнгөн-Эрдэнэ, нягтлан бодогч Д.Балжинням нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

Г.ИЧИНХОРЛОО

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043